



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 13

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах, үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 6 дугаар зүйлийн 6.4.2, 6.4.3, 6.4.6, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Эрдэнэдалай сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 237,680,366.62 /хоёр зуун гучин долоон сая зургаан зуун наян мянга гурван зуун жаран зургаан төгрөг жаран хоёр мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй 12 айлын орон сууц, халуун усны барилгыг нэгдүгээр хавсралтаар, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 19,522,969 /арван есөн сая таван зуун хорин хоёр мянга есөн зуун жаран ес/ төгрөгийн балансын үнэтэй хуучин амбулаторын барилга, склад граашийн барилгыг хоёрдугаар хавсралтаар, Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 21,319,099 /хорин нэгэн сая гурван зуун арван есөн мянга ерэн ес/ төгрөгийн балансын үнэтэй хуучин гал тогооны барилгыг гуравдугаар хавсралтаар акталж данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, Соёлын төвийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 103,447,568.67 /нэг зуун гурван сая дөрвөн зуун дөчин долоон мянга таван зуун жаран найман төгрөг жаран долоон мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй барилгыг суурин газрын хамт дөрөвдүгээр хавсралтаар Эрдэнэдалай сумын Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Эрдэнэдалай сумын Засаг даргын тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр), Эрүүл мэндийн төвийн дарга (Э.Насандэлгэр), Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Л.Буянтогтох), Соёлын төвийн эрхлэгч (Ө.Эрдэнэчимэг) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, акталснаас гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

2.2 Үл хөдлөх хөрөнгийг акталж, акталснаас гарсан хог хаягдлыг цэвэрлэж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ


Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн  
2-дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын актлах барилгын мэдээлэл

д/д	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтанд орсон он	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	12 айлын орон сууц	1990	1	196,668,871.60	39,333,774.24	157,335,097.36
2	Халуун усны барилга	1990	1	41,011,495.02	15,379,310.52	25,632,184.50
	<b>Хөрөнгийн нийт дүн</b>			<b>237,680,366.62</b> /хоёр зуун гучин долоон сая зургаан зуун наян мянга гурван зуун жаран зургаан төгрөг жаран хоёр мөнгө/	<b>54,713,084.76</b> /тавин дөрвөн сая долоон зуун арван гурван мянга наян дөрвөн төгрөг далан зургаан мөнгө/	<b>182,967,281.86</b> /нэг зуун наян хоёр сая есөн зуун жаран долоон мянга долоон хоёр зуун наян нэгэн төгрөг наян зургаан мөнгө/

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн  
2.8 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төвийн ахлах барилгын мэдээлэл

д/д	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Амбулаторын барилга	1963.10.20	1	16,557,599	12,418,199.28	4,139,399.72
2	Склад грааш	1984.11.01	1	2,965,370	2,224,027.44	741,342.56
	<b>Хөрөнгийн нийт дүн</b>			<b>19,522,969</b> /арван есөн сая таван зуун хорин хоёр мянга есөн зуун жаран ес/	<b>14,642,226.72</b> /арван дөрвөн сая зургаан зуун дөчин хоёр мянга хоёр зуун хорин зургаан төгрөг далан хоёр мөнгө/	<b>4,880,742.28</b> /дөрвөн сая найман зуун наян мянга долоон зуун дөчин хоёр төгрөг хорин найман мөнгө/

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн  
 23-дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



Эрдэнэдалай сумын Ерөнхий боловсролын сургуулийн актлах барилгын мэдээлэл

д/д	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Гал тогоо /хуучин/	1983.08.25	1	21,319,099	1,776,592	19,542,507
	<b>Хөрөнгийн нийт дүн</b>			<b>21,319,099</b> /хорин нэгэн сая гурван зуун арван есөн мянга ерэн ес/ төгрөг	<b>1,776,592</b> /нэг сая долоон зуун далан зургаан мянга таван зуун ерэн хоёр/ төгрөг	<b>19,542,507</b> /арван есөн сая таван зуун дөчин хоёр мянга таван зуун долоо/ төгрөг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн  
25 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

Эрдэнэдалай сумын Соёлын төвийн балансас балансад шилжүүлэх  
барилгын мэдээлэл

д/д	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Соёлын төвийн барилга	1974.09.01	1	103,447,568.67	3,474,708.60	99,972,860.07
2	Эзэмшил газар		1257м2	2,514,000		2,514,000
	<b>Хөрөнгийн нийт дүн</b>			<b>105,961,568.67</b> /нэг зуун таван сая есөн зуун жаран нэгэн мянга таван зуун жаран найман төгрөг жаран долоон мөнгө/		<b>102,486,860.07</b> /нэг зуун хоёр сая дөрвөн зуун наян зургаан мянга найман зуун жаран төгрөг долоон мөнгө/



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН  
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум

Утас: 70593232, 70593399

e-mail: umch@dundgovi.gov.mn

2022.04.15

№

79

танай

-ны №

-т

**ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН  
СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
Ө.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА**

Танай ирүүлсэн хүсэлтийн дагуу Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 23 дугаар тогтоол гарсан тул тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлнэ үү.

Хавсралт... хуудас

**ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ**



**Ж.БАНТУЛГА**



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН  
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум

Утас: 70593232, 70593399

e-mail: umch@dundgovi.gov.mn

2022. 04. 15 № 80

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

┌ **ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ** ┐  
**ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА**  
**Г.ЭНХДЭЛГЭР ТАНАА**

Танай ирүүлсэн хүсэлтийн дагуу Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 23 дугаар тогтоол гарсан тул тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлнэ үү.

Хавсралт... хуудас

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.АНТУЛГА







**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН  
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум

Утас: 70593232, 70593399

e-mail: umch@dundgovi.gov.mn

2022. 04. 15

№

83

танай

-ны №

-т

**ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Э.НАСАНДЭЛГЭР ТАНАА**

Танай ирүүлсэн хүсэлтийн дагуу Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 23 дугаар тогтоол гарсан тул тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлнэ үү.

Хавсралт... хуудас

**ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ** **Ж.АНТУЛГА**

